



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

213 /213/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.12.28

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ



АМЖИЛТ ГАРГАСАН ТАМИРЧДЫГ ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Алдар" спорт хорооны зарим тамирчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Тодруулбал, Тайланд Улсад зохион байгуулагдсан

"Олон өдрийн дугуйн уралдаан"-д амжилттай оролцож тэргүүн байрт шалгаран "Шар цамц"-ны эзнээр тодорсон С.Жамбалжамц, Турк Улсад зохион байгуулагдсан Олон улсын паратаеквондогийн ДАШТ-ий алтан

медалийн эзэн Г.Болор-Эрдэнэ болон тус тэмцээнээс хүрэл медаль хүртсэн Х.Энхтуяа нарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн юм.

Тэрээр амжилт гаргасан тамирчдад баяр хүргэж хэлсэн үгэндээ, цаашид олимп, тив, дэлхийн чанартай спортын наадмуудад улам амжилттай оролцож, салбарынхаа нэр хүндийг өндөрт өргөж явахын ерөөлийг дэвшүүлэв.

Энэ үеэр "Алдар" спорт хорооны тамирчин С.Жамбалжамц "Тус тэмцээнд 20 орны 15 багийн элит ангиллын 85 тамирчин хурд, хүчээ сорин уралдсан. Тэмцээнд тэргүүн байрыг эзэлсэндээ маш их баяртай байна. Ард минь түшиж тулж байсан бүх хүнд баярлаж талархсанаа илэрхийлье. Монгол, Тайланд хоёр улсын цаг агаарын хувьд нэлээд зөрүүтэй байсан ч бэлтгэлээ маш сайн базааж чадсаны үр дүнд амжилт гаргаж эх орондоо анх удаа анхны мэргэжлийн тэмцээний аваргын "Шар цамц"-ыг авчирлаа" гэв. Түүнчлэн Г.Болор-Эрдэнэ "Би таеквондогийн

спортоор 12 дахь жилдээ хичээллэж байна. Энэ удаагийн ДАШТ-ий тэргүүн байрыг эзэлснээр дэлхийн таван удаагийн аварга болж байна. Өнгөрсөн олимпын наадмаас алтан медаль хүртэх зорилгыг тээсэн ч үүргээ харахан гүйцэтгэж чадсангүй. Гэхдээ сая зохиогдсон тэмцээнд олимпын аваргыг ялж аваргалсандаа туйлын их урамшиж байгаа. Намайг үргэлж тусалж дэмждэг "Алдар" спорт хорооны нийт алба хаагчдадаа талархаж буйгаа илэрхийлье. Мөн ирэх олимпын наадамд амжилт гаргахын төлөө хичээнгүйлэн зүтгэх болно" гэсэн юм. Тэгвэл Х.Энхтуяа "Миний хувьд энэ тэмцээнээс 2017 онд алт, 2019 онд мөнгөн медалийг хүртэж байсан бол энэ онд хүрэл медалийн эзэн боллоо. Тус тэмцээнд медалийн байр эзэлснээр ирэх "Парис-2024" олимпын наадамд оролцох эрхийн оноогоо нэмэгдүүлж чадлаа. Цаашид батлан хамгаалах салбар, "Алдар" спорт хорооныхоо нэр хүндийг илүү өндөрт өргөхийн төлөө хичээх болно" гэж онцолсон юм.

Түүхэнд энэ өдөр

1912 он.

Богд хааны зарлигаар "Дайчилсан болон илгээсэн цэргийн дагаж явах түр дүрэм хэмжээ"-г баталжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-11	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,846.0	2,851.0
EUR	3,225.0	3,237.0
CNY	431.00	436.00
RUB	36.38	39.10
JPY	24.90	25.00
KRW	2.39	2.40

ЗУРХАЙ

2021.12.28 МЯГТАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 24/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР ҮС ЗАСУУЛАЛ:

Өвчин эмгэг ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.41-17.06
БАРИЛДАГА: Түлэх
ШҮТЭН БАРИЛДАГА: Нэр өнгө
Суудал: Төмөр

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, баш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, андагй тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Монгол Улсад Үндэсний эрх чөлөөний хувьсгал өрнөж, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын түүхт 110 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Материал техникийн газрын нийт бие бүрэлдэхүүн нэгдсэн тооллого явууллаа. ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг нэгдсэн тооллогыг удирдан явуулсан юм.

ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн дарга, төрлийн цэргийн командлагч, удирдах газрын дарга нар тооллого явуулж, ЗХЖШ-ын даргад илтгэл өгсний дараа бие бүрэлдэхүүн Цэргийн тангараг давтаж, Монгол Улсын Төрийн дууллыг эгшиглүүлэв.

Дэслэгч генерал Д.Ганзориг "Бид 2021 онд өмнөө тавьсан зорилго зорилтуудаа хангаж, үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн гэдгийг хэлмээр байна. Тиймээс та бүхэнд болон ар талыг тань найдвартай дааж албандаа хоёргүй сэтгэлээр зүтгэхэд цаг ямагт тусалж дэмждэг гэр бүлийнхэнд нь талархал дэвшүүлье" гэв.

Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний тэргүүний анги, салбар болон ЗХЖШ-ын 2021 оны тэргүүний зохион байгуулалтын бүтцийн нэгж, алба хаагчдад шагнал гардуулах ёслолын ажиллагаа болов.

ЗХЖШ-ын 2021 оны "Тэргүүний зохион байгуулалтын бүтцийн нэгж"-ээр Эрүүл мэндийн хэлтэс, "Тэргүүний удирдах албан тушаалтан"-аар Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга хурандаа Ж.Хоролсүрэн, "Тэргүүний ахлах

мэргэжилтэн"-ээр Санхүүгийн хэлтсийн Төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн ахлах мэргэжилтэн хурандаа П.Эрдэнэбаяр, "Тэргүүний мэргэжилтэн"-ээр Материал, техникийн газрын Орон сууцны хэлтсийн барилга цахилгаан, тоног төхөөрөмжийн мэргэжилтэн ахмад Л.Сүрэн, "Тэргүүний туслах мэргэжилтэн"-ээр Хүний нөөцийн хэлтсийн ахлагчийн нөхөн хангалтын мэргэжилтэн сургагч ахлагч Б.Энхбаяр, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн мужаан Э.Нямлхагва нар шалгарлаа.

Мөн Зэвсэгт хүчний "Тэргүүний анги"-аар хурандаа М.Батдорж захирагчтай 011 дүгээр анги, "Тэргүүний салбар"-аар дэд хурандаа У.Ганзам захирагчтай Зэвсэгт хүчний нэгдсэн лаборатори, "Тэргүүний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч алба"-аар хурандаа Ш.Цэрэнбат захирагчтай 065 дугаар ангийн тонн систем автоматжуулалтын алба, "Тэргүүний шинийг санаачлагч алба хаагч"-аар 189 дүгээр ангийн програм хангамжийн төвийн өгөгдлийн сангийн аюулгүй байдлын шинжээч ахмад Б.Даваабат, "Тэргүүний офицер"-оор 350 дугаар ангийн ажиллагааны удирдлагын тасгийн ажиллагааны ахлах офицер ахмад Б.Цээноров, "Тэргүүний ахлагч"-аар 123 дугаар ангийн үлээвэр найрал хөгжмийн салааны бялар бүрээчин ахлах ахлагч Э.Даваажамц, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар 032 дугаар ангийн үйлчлэх хэсгийн слесарь Ш.Ганбат, "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар 339 дүгээр ангийн замын ротын ажлын салааны замчин байлдагч Ж.Шаравням нар тодорсон юм.

ТАЙВАН ЦАГТ ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ БАТАЛЛАА



"Төрийн цэргийн байгууллагуудын тайван цагт харилцан ажиллах журам"-ыг батлах арга хэмжээ өчигдөр ЗХЖШ-т болж өндөрлөв. Тус үйл ажиллагаанд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ОБЕГ-ын дарга хошууч генерал Г.Ариунбуян, Дотоодын цэргийн штабын дарга хурандаа Р.Чингис, ХХЕГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит эрхэлсэн дэд дарга хурандаа П.Мөнх-Эрдэнэ, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалын удирдлагууд болон холбогдох албан тушаалтнууд оролцов.

Энэ үеэр ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг хэлсэн үгэндээ "Төрийн цэргийн байгууллагуудын тайван цагийн харилцан ажиллагааг эрчимжүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах чиглэлээр өнгөрсөн хугацаанд та бидний хооронд яригдсан яриа, хэлцэл өнөөдөр үр дүнгээ өгч байна. Хамтын ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр дараагийн шатны чухал баримт бичиг болох "Төрийн цэргийн байгууллагуудын тайван цагт

харилцан ажиллах журам" батлагдсанаар харилцан ажиллах төлөвлөгөөг бид хамтран боловсруулж, хэрэгжүүлэх боломж бүрдэж байна. Цаашид бидний харилцан ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаас баталсан бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан нэгдмэл, харилцан уялдаатайгаар зохион байгуулах, хамтын хүчээр уламжлалт болон уламжлалт бус аюулаас сэргийлэх, хамгаалах боломж нэмэгдэнэ гэж үзэж байна" гэв.

БАРИЛГАЧИН ДАЙЧИД ОНЫ ТЭРГҮҮНҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА



Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар оны тэргүүнүүдээ шалгарууллаа. Удирдах газрын 2021 оны "Тэргүүний зохион байгуулалтын нэгж"-ээр хурандаа Ц.Баяргэрэл даргатай Санхүүгийн хэлтэс, "Тэргүүний мэргэжилтэн"-ээр Цэргийн мэргэжлийн удирдлагын хэлтсийн Мэдээллийн аюулгүй байдлын офицер ахмад Б.Энхсансар, Материал хангалтын хэлтсийн хувцасны хангалтын мэргэжилтэн хошууч Ц.Жүндүүлхам, Захиргааны удирдлагын хэлтсийн нууцын хэрэг хөтлөгч сургагч ахлагч М.Сайнхүү, "Тэргүүний анги"-аар хурандаа Б.Дорждэрэм захирагчтай 017 дугаар анги, "Тэргүүний салбар"-аар дэслэгч Ц.Ууганбаяр захирагчтай 110 дугаар ангийн

Барилга угсралт, засварын рот, "Тэргүүний офицер"-оор 340 дүгээр ангийн Ажиллагааны удирдлагын тасгийн дарга, ажиллагааны ахлах офицер ???Б.Ууганбаатар, "Тэргүүний ахлагч"-аар 339 дүгээр ангийн Барилга угсралт, засварын ротын тасгийн захирагч, арматурчин ахлагч З.Батхуяг нар шалгарлаа. Мөн "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар 339 дүгээр ангийн Замын ротын замчин байлдагч Ж.Шаравням, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар 338 дугаар ангийн талхан цехийн эрхлэгч, нярав С.Гэрэлтуяа, "Бүтээн байгуулагч анги"-аар хошууч генерал П.Дорждэрэм захирагчтай 7781 дүгээр анги, "Бүтээн байгуулагч офицер"-оор 7780 дугаар

ангийн зураг төслийн инженер ахлах дэслэгч Б.Дэлгэржав, "Бүтээн байгуулагч ахлагч"-аар 7782 дугаар ангийн экскаваторчин ахлагч У.Бат-Өлзий, "Бүтээн байгуулагч ажилтан албан хаагч"-аар тус ангийн хийц угсрагч мужаан Ш.Арсланбаатар нар тодорсон бөгөөд шагналыг Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан гардуулан өгсөн юм.

Тэрээр "Улиран одож буй 2021 онд улс орныг хөгжүүлэх стратегийн ач холбогдол бүхий томоохон бүтээн байгуулалтын болон байгаль орчин экологийн ажлуудыг бид чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэлээ. Энэ их хөдөлмөрийн нэгээхэн хэсэг нь та бүхний ар талыг найдвартай дааж байсан та бүхний гэр бүл, үр хүүхдүүдэд чин сэтгэлийн халуун баярыг хүргэж байна. Сурсан мэдсэн бүхнээ улам батгаж, инновацад суурилсан үйлдвэрлэлийг нэвтрүүлэн энх цагийн бүтээн байгуулалтад идэвх зүтгэлтэй оролцож, Зэвсэгт хүчний хөгжлийн төлөө түүчээлэн ажиллахыг нийт бие бүрэлдэхүүнд уриалахын ялдамд 2021 оны манлайлагч та бүхэнд ирж буй шинэ ондоо амжилт бүтээл дүүрэн байхыг бэлгэдэж, эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе" гэлээ.



АГААРЫН ЦЭРГИЙН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын энэ оны шилдгүүд тодорлоо. Агаарын цэргийн командлалын "Тэргүүний бүтцийн нэгж"-ээр Удирдлага төлөвлөлтийн хэлтэс, "Тэргүүний удирдах ажилтан"-аар Материал техникийн хэлтсийн дарга хурандаа Г.Хашчулуун, "Тэргүүний офицер"-оор Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн ажиллагааны удирдлагын ахлах офицер, тагнуулын дарга хурандаа Ч.Буянзаяа, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар Материал техникийн хэлтсийн үйлчлэгч Ж.Чулуунцэцэг нар шалгарав. Мөн Агаарын цэргийн "Тэргүүний анги"-аар хурандаа Д.Шатаррагчаа захирагчтай Зэвсэгт хүчний 303 дугаар анги, "Тэргүүний салбар"-аар хошууч Д.Мөнхзул захирагчтай 325 дугаар ангийн харьяа 116 дугаар тусгай салбар, "Тэргүүний офицер"-оор хошууч Д.Мөнхзул "Тэргүүний



ахлагч"-аар 065 дугаар ангийн холбооны албаны холбооны засварчин, жолооч сургагч ахлагч Ц.Болдбаатар, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар 353 дугаар ангийн материал техникийн хангалтын салбарын орон сууц ашиглалтын хэсгийн уурын зуухны механикч Б.Бат-Эрдэнэ нар шалгарсан юм. Шагналыг Агаарын цэргийн командлагч хошууч

генерал О.Энхбаяр, Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Б.Энхзоргол нар гардуулав. Энэ үеэр "Шинэ төмөр зам" төслийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад амжилттай оролцсон бүрэлдэхүүнд батламж гардуулж, тус командлалын ахлагчаар ажиллаж байсан тэргүүн ахлагч О.Батбаярт хүндэтгэл үзүүлээ. Төгсгөлд нь хошууч генерал О.Энхбаяр "Бидний

хувьд улиран одож буй 2021 он цаасан дээр буусан төлөвлөгөө, арга хэмжээнүүд бодит ажил болж хэрэгжсэн, түүнийхээ үр дүнг үзсэн ололт амжилт дүүрэн жил байлаа" хэмээн онцлоод бие бүрэлдэхүүнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсэн ерөөв.

АНГИЙН ОНЫ ШИЛДГҮҮД ТОДРОВ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги Цэргийн гавьяаны одонт БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Зэвсэгт хүчний 167 дугаар

анги 2021 оны ажил үйлсээ дүгнэж ажил үйлсээрээ бусдыгаа манлайлагч хамт олон, аваргуудаа тодрууллаа. "Тэргүүний хамт олон"-оор дэслэгч Г.Энхмаа даргатай Эмнэлгийн алба, эрүүл

мэндийн төвийн хамт олон, "Тэргүүний офицер"-оор ахмад Г.Баттөр, "Тэргүүний ахлагч"-аар ахлах ахлагч Ж.Дондогмаа, "Тэргүүний ажилтан"-аар С.Батсуурь, "Ажил мэргэжлийн аварга офицер"-оор ахлах дэслэгч Э.Мөнхгэрэл, "Ажил мэргэжлийн аварга ахлагч"-аар дэд ахлагч Б.Баасанцэрэн, "Ажил мэргэжлийн аварга ажилтан"-аар Б.Туяасүрэн, "Бүтээлч ажилтан"-аар дэд ахлагч Л.Эрдэнэбаатар, дэд ахлагч Б.Бямбадэлгэр, энгийн Ш.Адъяабаатар нар шалгарч, шагналыг нь ангийн захирагч хурандаа Ж.Амаржаргал нарын удирдлагууд гардуулан өгсөн юм.

Дэслэгч Г. НАНДИНЧИМЭГ

2021 ОНЫ ТЭРГҮҮНИЙ АЛБА ХААГЧДАА ТОДРУУЛЛАА



Зэвсэгт хүчний 256 дугаар анги Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 256 дугаар анги 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангийн хурлаа зохион байгуулж бусдыгаа манлайлсан тэргүүний алба, офицер, ахлагч, ажилтан алба хаагч, цэргийн гэрээт алба хаагч нарыг тус тус шалгарууллаа.

"Тэргүүний алба"-аар зэвсгийн алба, "Тэргүүний Офицер"-оор дайчилгааны ахлах офицер хошууч С.Ганбат, "Тэргүүний ахлагч"-аар Техник шалгах байрны дарга ахлах ахлагч Т.Хадбаатар, "Тэргүүний ажилтан албан хаагч"-аар Цайны газрын эрхлэгч, тогооч Ц.Анхтуяа, "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар О.Лхамноргим нар шалгарлаа.

Мөн энэ үеэр Хуурай замын цэргийн командлагчийн болон ангийн захирагчийн тушаалаар зарим офицер, ахлагч нарт албан тушаалын дагуу цэргийн цол олголоо.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)